



УЛААНБААТАР

хотын Ардын Депутатуудын хурлын Гүйцэтгэх Захиргааны ТОГТООЛ

1980 оны 12 дугаар
сарын 18 ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 318

КОМИССЫН ДЭЛГҮҮР АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ

Октябрийн районы 3-р хороололд ЗХУ-ын тусламжаар иж бүрэн төхөөрөмжлөгдсөн комиссын худалдааны дэлгүүр ашиглалтанд орж байгаатай холбогдуулан Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ НЬ:

1.3-р хороололд комиссын хуралдааны дэлгүүрийг энэ оны 12-р сарын 25-наас эхлэн нээн ажиллуулж Комиссын худалдааны 1-р дэлгүүр нэрлэн одоогийн ажиллаж байгаа 2-р дэлгүүрийг түүнд харъяалуулсугай.

А.ХХГЗ-ийн 1989 оны 161-р тогтоолоор хуульчилсан

~~2.Комиссын худалдааны 1-р дэлгүүрийн түр орон тоог хавсралтаар баталсугай.~~

3.Хүлээн авч байгаа бараанд жижиг засвар хийх, овор ихтэй барааг гэрт нь хүргэж үйлчлэх, барааны борлуулалтыг эзэнд нь мэдээлэх зэрэг нэмэлт үйлчилгээ, дэвшилтэт хэлбэрийг тууштай нэвтрүүлэхийг Хотын худалдаа удирдах газар /н.Шагдар/-т даалгасугай.

4.Овор ихтэй барааг гэрт нь хүргэж үйлчлэхэд шаардагдах авто машинаар хангахыг хотын Тээврийг удирдах газар /н.Сэрээтэр/-т даалгасугай.

5.Комиссын худалдааны захиргааны орон тоо, цалингийн фондыг энэ онд багтаан Хөдөлмөр, цалин хөлсний улсын хооронд оруулж шийдвэрлүүлэхийг Санхүүгийн хэлтэс /н.Эрдэмбат/


2.

хотын Худалдаа удирдах газар /н.Шагдар/-т даалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРГА *[Signature]* С.МОНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА *[Signature]* Ч.ЖАМБАЛ



Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1980 оны 318-р тогтоолын хавсралт

КОМИССЫН ХУДАЛДААНЫ I-Р ДЭЛГҮҮРИЙН ТҮР ОРОН ТОО

д / д ! Албан тушаал	түр орон тоо
I.Тооцооны ня-бо	2
2.Заалын зохион байгуулагч	I
3.Барааны мэргэжилтэн	2
4.Мөнгөний нярав	I
5.Нярав	2
6.Кассчин	3
7.Худалдагч	I8
8.Манаач	3
9.Цэвэрлэгч	3
10.Туслах ажилчин	2
II.Мужаан, цахилгаанчин	I
БҮГД	38

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГАА